

доктор Я.Шийлэгмаа  
/МУБИС, Эрдэм шинжилгээ, инновацын албаны дарга/

### Хураангуй.

ЮНЕСКО-оос гаргасан судалгаагаар 2020 оны 3 сард 1.5 тэрбум оюутан сурагчид цар тахлын улмаас онлайн сургалтад шилжсэн байна. Ийм нөхцөлд багш, сурган хүмүүжүүлэгчдэд хичээл заах хуучин аргаасаа салж, шинэ заах арга хэрэглэх шаардлага тулгарч байна. Бүтээлч сэтгэлгээ, инновацын ач холбогдол эрс өсөж, авьяасын эрэлт хэрэгцээ нэмэгдэж, мэдээллийн технологийн шинэ хэрэгсэлүүд бий болж, боловсролын салбарт парадигмийн шилжилт хийх шаардлага тулгарч буй өнөө үед аль ч шатны сургуулийн багш дизайнер байх шаардлага тавигдаж байна.

Дизайнер багшийн 7 шинж чанарыг дараах байдлаар тодорхойлж байна.

1. Бүтээлч сэтгэлгээ-оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхийн тулд тэдний хэрэгцээнд нийцсэн сургалтын янз бүрийн аргыг хэрэглэж бүтээлч сэтгэлгээг дэмждэг байх
2. Сониуч зантай байх-багш үргэлж шинийг эрэлхийлж, шинэ санааг эрж хайж, туршиж, хөгжүүлж чаддаг байх
3. Насан туршдаа сурах хүсэл эрмэлзэлтэй байх-Багш бол насан туршдаа суралцаж, арвин туршлага хуримтлуулж, оюутнуудынхаа сурах хэрэгцээ шаардлагад нийцсэн дэмжлэг үзүүлж байх
4. Алдаа хийхээс айдаггүй байх-Багш бол шинэ зүйлийг сурах, турших, алдаа хийхээс айхгүй, алдааг боломж гэж харж чаддаг байх
5. Бусадтай хамтран ажиллах ур чадвар-Оюутнуудтайгаа хамтран асуудлыг хэлэлцэж, тэдний суралцахуйн үр дүнг дээшлүүлж чаддаг байх
6. Энэрэнгүй байх-багш өөрийн ажилдаа үнэнч, сэтгэлтэй хандаж, оюутныг ойлгож, тэднийг оюун ухааны төдийгүй сэтгэл санааны хувьд дэмждэг байх
7. Эдгээр шинж чанарыг эзэмшиж чадвал багш боловсролын салбарын өөрчлөлт, парадигмийн шилжилтийг хийх хүч болж чадна.

Өнөөдөр багш нарын мэргэжил дээшлүүлэх агуулгад дараах зүйлсийг тусгах шаардлага бий болж байна.

1. Мэдлэгийн нийгмийн шинэ хэрэгцээ. Өнөөдөр шинэ мэдлэг илүү хурдацтай бий болсоор байна. Багш нарт насан туршид нь суралцах сургалтын хөтөлбөрийг бий болгох шаардлага бий боллоо.
2. Сурагчдын хүлээлт өөрчлөгдөж байна. Мөн сурагчдын хэв шинж өөрчлөгдөж байна. Өнөөдрийн суралцагсад технологитой хамт өсөж, сурч байгаа учраас сурах үйл ажиллагаандаа технолги хэрэглэхийг эрмэлзэх болжээ. Хосолсон болон онлайн сургалт сургуулийн стратегийн тэргүүлэх чиглэл болж байна
3. Ажлын байр шинэчлэгдэн өөрчлөгдөж байна. Төсөлд суурилсан ажил, зохион байгуулалтын хэвтээ бүтэц, хүн-технологийн шинэ харьцаа зэрэг нь ажлын байран дээр ур чадвараа дээшлүүлэх хэрэгцээг улам өргөтгөж байна. Энэ бүх өөрчлөлт хаана хэзээ ч, байнга сурч байх шаардлагыг тавих болжээ.

Эдгээр шинэ өөрчлөлтөд заах арга зүй хэрхэн өөрчлөгдөж, суралцахуйг яаж явуулах талаар товчхон дурдая.

1. Хосолсон сургалт. Сургалтыг хосолсон болон тонгоруу аргаар явуулахын тулд сургалтын процессыг сайтар эргэн харж, сурах орчны дизайнаас эхлээд суралцахуйн дизайныг цоо шинээр хийх шаардлага тулгарч байна

2. Мэдлэг бүтээхэд хамтран ажиллах. Багшийн хувьд хичээл заах ажил эрс багасаж өөрийн үүрэг, эрх мэдлээ эргэн харж суралцахуйг хэрхэн өгөөжтэй явуулахад анхаарлаа хандуулах шаардлага тулгарч байна.
3. Сургалтын нээлттэй нөөц материал ашиглах.
4. Сэтгэл судлал, тархи судлал, сургах арга зүйг чадварлагаар хослуулан хэрэглэж сурах шаардлага багш нарт тавигдаж байна.
5. Мэдлэг үнэлэх цоо шинэ хэлбэрийг нэвтрүүлэх шаардлагатай. Мэдлэгийн үнэлгээг торгууль шийтгэл бус урамшуулал болгож, алдааны учир шалтгааныг олж авахад нь туслахыг урьтал болгох хэрэгтэй. Суралцагсдыг өөр өөрсдөөр нь дүгнүүлэх, хөндлөнгийн үнэлгээ хийх нь үр өгөөж сайтай байдаг.

### **ДҮГНЭЛТ**

Багш нарыг чадавхижуулах арга хэмжээг зохион байгуулахад дараах асуудалд анхаарч ажиллах нь чухал хэмээн үзэж байна.

1. Сурахуйн зорилтот үр дүнд мэргэжлийн ажил мэргэжлийн хүрээ, мэргэжлийн холбоодын шаардлага, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг тусгасан байх
2. Төгсөгчийн жишиг загварт үндэслэн, төгсөгчийн цогц чадамж буюу хөтөлбөрийн зорилтот үр дүнг тодорхойлсон байх
3. Зорилтот үр дүнг өгөгдсөн хугацаа, нөөц бололцоог харгалзан бодитой, биелэгдэж болохуйц байдлаар тодорхойлсон байх
4. Нэгж хичээлүүдийн сурахуйн зорилтот үр дүн нь бакалаврын хөтөлбөрийн зорилтот үр дүнтэй уялдсан байх
5. Сурахуйн зорилтот үр дүнг оюутны хөгжүүлэх чадваруудыг илтгэх идэвхт үйл үгээр илэрхийлж тодорхойлсон байх
6. Сурахуйн зорилтот үр дүнтэй уялдаатай шалгалт, үнэлгээний хэлбэрийг сонгосон байх
7. Зорилтот үр дүнд хүрэх хамгийн тохиромжит идэвхтэй сургалтын хэлбэр, заах сурахуйн арга ажиллагааг оруулсан байх
8. Зорилтот үр дүнг бодитой, зөв тодорхойлсон эсэх дээр дүн шинжилгээ хийж, засаж залруулдаг тогтсон ажиллагаатай байх зэрэг болно.

---oOo---